- 3.1 Энэхүү гэрээгээр дараах үнээр эмнэлгийн үйлчилгээг үзүүлнэ:
  - 3.1.1 МҮ-ын иргэдэд 1 удаагийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ -40000 төгрөг. Үүнд эрүүл мэндийн үзлэгийн дэвтрин үнэ ороогүй. НӨАТ ороогүй.
- 3.2 Төлбөрийн нөхцөл: Гүйцэтгэгч нь шаардлагатай бол Захиалагчид үзүүлэх үйлчилгээний төлбөрийн нэхэмжлэлийг өгч болно Захиалагч нь нэхэмжлэлийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор үйлчилгээний төлбөрийг Гүйцэтгэчийн ХУДЭМТ-ийн кассанд зсэвл **Төрийн сангийн 100200120001 тоот төгрөгийн харилцах** дансанд шилжүүлнэ. Хүлээн авагч байгууллага ХУД Эрүүл мэндийн нэгдэл. Шинээр ажил горилогчийн эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний төлбөрийг ажил горилогч өөрөө гүйцэтгэгч талын кассанд тушаана.

### 4. Талуудын эрх, үүрэг

#### Захиалагчийн үүрэг:

- 4.1 Эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт Захиалагч талаас хариуцсан ажилтныг томилно, үзлэг хийхэд шаардлагатай мэдээллээр хангана, үзлэгт буюу шинжилгээнд орох ажилд шинээр орох иргэд, ажилчдыг өөрсдийг нь явуулна.
- 4.2 Эмнэлгийн урьдчилсан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдах ажилд шинээр орох иргэд, өөрийн ажилчдын нэrsийн жагсаалтыг гаргаж, үзлэгт орохоос хуанлийн 14 хоногийн өмнө гүйцэтгэгчид биеэр хүргүүлнэ.
- 4.3 Гүйцэтгэгчтэй харилцан товлосон хугацааны дагуу ажилд шинээр орох иргэд, өөрийн ажилчдыг бүрэн хамруулна Эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт ороогүй бусад иргэд, ажилчдыг хуанлийн 14 хоногийн дотор хамруулах ажлыг зохион байгуулна.
- 4.4 Гүйцэтгэгчийн нэхэмжлэлийг хүлээн авч, төлбөрийг гэрээнд заасан хугацаанд шилжүүлнэ.
- 4.5 Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдаагүй иргэн, ажилчдыг ажиллуулахыг хориглоно.
- 4.6 Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний дүн зерэг гарсан ажилтнуудыг зэмчилж, эрүүлжүүлэх ажлыг мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэнэ.
- 4.7 Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамрагдсан байдал, баталгаажуултанд хяналт тавьж ажиллана
- 4.8 Гэрээнд заагдан ажилтан халдварт өвчинеэр өвчилсөн буюу өвчтөнтэй хавьтал болсон ажилтныг тухай бүр эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулна

#### Гүйцэтгэгчийн үүрэг:

- 4.9 Захиалагчийн ажилд шинээр орох иргэн, захиалагчийн ажилчдад эмнэлгийн урьдчилсан үзлэг, шинжилгээг Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн яамнаас баталсан холбогдох дүрэж журам, стандартын шаардлага, аргачлалын дагуу зохион байгуулж гүйцэтгэнэ
- 4.10 Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний үр дунг эмч болон эмнэлгийн удирдлага гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна
- 4.11 Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний дүн "зерэг" гарсан иргэн, ажилтанд зөвлөгөө өгч холбогдох арга хэмжээг авна
- 4.12 Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ хийх зөвшөөрлийг холбогдох эрх бүхий байгууллагаас авсан байна.
- 4.13 Батлагдсан затварын эрүүл мэндийн дэвтррийг ашиглана
- 4.14 Урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ бүрэн хийгдээгүй, лабораторийн шинжилгээний хариу бичигдээгүй тохиолдолд баталгаажуулахыг болон эрүүл мэндийн дэвтррийг засварлахыг хориглоно

## 5. Талуудын хариуцлага

- 5.1. Захиалагч гэрээний төлбөрийн хугацааг хэтрүүлсэн тохиолдолд хугацаа хэтэрсон хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн 0,1% тэнцэх алдангийг гүйцэтгэгчид төлнө
- 5.2. Талуудын батлагдсан эмнэлгийн урьдчилсан узлаг, шинжилгээний товлосон хугацаанд ажилтан хүндэтгэн үзэх шалтгаанаар хамрагдах боломжгүй тохиолдолд захиалагч энэ тухай гүйцэтгэгчид ажлын 5 хоногийн дотор мэдэгдэнэ.
- 5.3. Гүйцэтгэгч гэрээний үүргээ гүйцэтгээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд хуулийн дагуу арга хэмжээ хүлээнэ.

## 6. Мэдээллийн нууцлал

- 6.1. Энэхүү гэрээ түүний нөхцөл, гэрээтэй холбогдуулан талуудын шууд болон шууд бусаар олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцад хамааралтай аливаа мэдээллийг /цаашид "Мэдээлэл" гэх/ бусдад задруулахгүй байх үүргийг талууд байгууллагын нууцын тухай хууль болон хувь хүний нууцын тухай хуулийн дагуу хүлээнэ.
- 6.2. Мэдээллийн нууцлалд дараах мэдээллүүд хамаарахгүй.
  - 6.2.1. Мэдээлэл нь мэдээ хүлээн авагч талд хүрэх үедээ олон нийтэд мэдэгдсэн байсан бол
  - 6.2.2. Мэдээллийг мэдээ хүлээн авагч талд гуравдагч этгээд өгөх тохиолдолд тэрхүү гуравдагч этгээд өөрийн мэдээллийн нууцын хадгалах ямар нэгэн гэрээгээр болон хуулиар хүлээсэн үүргээ зөрчвэгүй бол
  - 6.2.3. Мэдээ хүлээн авагч талд мэдээлэл хүргэх үед уг мэдээлэл нь түүнд өмнө нь хууль ёсны дагуу мэдэгдсэн байсан бол

## 7. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах

- 7.1. Энэхүү гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд эх хувьд засварласан буюу бусад аргаар оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтийг хүчингүйд тооцно. Энэхүү нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 7.2. Гэрээг дараах тохиолдолд цуцлаж болно:
  - 7.2.1. Талууд харилцан тохиролцсон бол бичгэн хэлбэрээр цуцална.
  - 7.2.2. Гүйцэтгэгч нь энэхүү гэрээний үүргээ биелүүлээгүй, гэрээний үүргээ ноцтой зөрчсөн тохиолдолд урьдчилан бичгээр мэдэгдсний үндсэн дээр захиалагч гэрээг дангаар цуцлах эрхтэй.

## 8. Давагдашгүй хүчин зүйл

- 8.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс /дайн, байлдаан, иргэний бослого хөдөлгөөн, нийтийг хамарсан өвчлөлт, бүслэлт байгалийн гамшиг, цахилгаан эрчим хүчиний саатал зэрэг аль нэг талын буруулаас үл хамаарах хүчин зүйлс/-ээс шалтгаалсан онцгой нөхцөл байдлын улмаас аль нэг тал нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд тухайн нөхцөл байдал дуусах хуртэлх хугацаанд энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөгднө.
- 8.2. Давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан онцгой нөхцөл байдал 3 /гурван/ сар хуртэл хугацаагаар ургэлжилвэл аль ч тал энэхүү гэрээг дангаар цуцлах эрхтэй.

## 9. Бусад нөхцөл

- 9.1. Энэхүү гэрээнээс үүсэх аливаа маргааныг талууд звийн журмаар хэлэлцэн шийдвэрлэхийг эрхэмлэнэ, ҳэлэлцээр үр дүнд хүрээгүй бол маргааныг МУ шүүхээр МУ хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.
- 9.2. Энэхүү гэрээгээр зохицуулагдаагүй асуудлыг талууд МУ хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.


- 9.3 Энэхүү гэрээний бүгд нэмэлт өөрчлөлтийд нь талуудын зөвхөн бичгээр үйлдэж гарын үсэг зурсан тохиолдолд хуулийн өмнө хүчин төгелдөр бөгөөд салшгүй зүйл гэж тооцогдоно.
- 9.4 Гэрээг хугацаанаас өмнө дангаар дараах тохиолдолд цуцална: гэрээний үүргээ удаа дараа /2-с дээш тохиолдолд/ зөрчсөн, захиалагчийн зорчигчдын амь нас, зруул мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан.
- 9.5 Энэхүү гэрээ монгол улсад хууль зүйн адил хүчинтэй хоёр хувь үйлдсэн тал болгонд нэг нэг хувь хадгалагдана.

#### 10. Төлбөр тооцоо

10.1 Нийт ажилчдын үзлэг шинжилгээний зардал нэг хүнд 40000 ₮ байхаар 110 хүний шинжилгээний төлбөр 4 400 000 /дөрвөн сая дөрвөн зуун мянган /төгрөг төлнө.

Талуудын гарын үсэг, мэдээлэл:

**Гүйцэтгэгч:**

Хан Уул дүүргийн Эрүүл мэндийн төв  
Хаяг: УБ, Хан-Уул дүүрэг, 3-р хороо  
Чингисийн өргөн чөлөө  
Утас: 1134587, 99201688  
Вэб сайт: [www.huern.ub.gov.mn](http://www.huern.ub.gov.mn)  
И-Мэйл хаяг:  
[khanuu@huern.ub.gov.mn](mailto:khanuu@huern.ub.gov.mn)  
Төв салбарын эрхлэгч  
Д.Молор-Эрдэнэ/  


**Захиалагч:**

Хаяг: Хан-Уул дүүрэг 13-р хороо Туул тосгон  
ТҮМЭН ШУВҮҮТ ХК өөрийн байр  
Утас: 98000010  
ХАБЭА МЕНЕЖЕР   
/Ц НЯМДОРЖ/  
Email:NYAMDORJ@TUMENSHUVUUT.MN

БАТЛАВ:

“ГРИЙН ХИМИСТРИ” ХХК-ИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ БДАВААЦЭРЭН

Огноо:



БАТЛАВ:

“ТҮМЭН ШУВУУТ” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Ж.БОЛД

Огноо:



## ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ

2020 оны 6-р сарын 8-ны өдөр

№. СН 23 - 20/06

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Монгол Улсын хуулийн этгээд болох “ГРИЙНХИМИСТРИ” ХХК (цаашид “Худалдагч” гэх)-ийг төлөөлж менежер О.Халиунаа нөгөө талаас Монгол Улсын хуулийн этгээд болох “ТҮМЭН ШУВУУТ” ХК (цаашид “Худалдан авагч” гэх)-ийг төлөөлж Чанарын менежер Ш.Алтантуяа нар (хамтад нь “Талууд” гэх) Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дугаар зүйл, үүргийн нийтлэг зохицуулалтыг тус тус үндэслэл болгон дараах нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Гэрээгээр Худалдагч нь чанарын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн/цаашид “Бараа” гэх/-ийг Худалдан авагчид урт хугацаанд давуу эрхтэйгээр нийлүүлэх, Худалдан авагч нь тогтвортой, хөнгөлттэй нөхцлөөр худалдан авалт хийх, барааны үнийг төлөхтэй холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Худалдан авах барааны тao хэмжээ болон үнийг тухай бүр эзвэл захиалгын гэрээ хийхэд тохиролцено.
- 1.3 Гэрээ нь хавсралттай байх бөгөөд хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 1.4 Худалдан авагч нь худалдагчид барааны үнийг бүрэн төлж барагдуулснаар түүнд өмчлөх эрх шилжинэ.
- 1.5 Гэрээний үргэлжлэх хугацаа 1 жил байна.

### ХОЁР. БАРАА НИЙЛҮҮЛЭХ, ТӨЛБӨР ТӨЛӨХ НӨХЦӨЛ

- 2.1 Худалдан авагч барааны хэмжээ, хүргэх огноо, шаардлагатай тохиолдолд хүргэх газрыг нарын тодорхой заасан байна.
- 2.2 Худалдан авагч нь гэрээний үнийг дараах нөхцлийн дагуу худалдагчид төлнэ. Үүнд:
  - 2.2.1 Худалдан авагч захиалгын бараа бүтээгдэхүүний урьдчилгаа 50%-ийг Худалдагчийн Голомт банкны 2205034984 тоот дансанд шилжүүлснээр захиалга батлагдсанд тооцогдоно. Үлдэгдэл төлбөрийг барааг хүлээн авч талууд акт үйлдсэнээс хойш Худалдагчийн нэхэмжлэхийг үндэслэн ажлын 3 хоногт багтаан төлнэ.
  - 2.2.2 Худалдан авагч гэрээгээр тохиролцсон төлбөрийг Худалдагчийн данс руу шилжүүлсэн өдрөөр төлбөрийг шилжүүлсэнд тооцно.
  - 2.2.3 Агуулахад бэлэн бараа бүтээгдэхүүнийг худалдан авахдаа худалдан авагч урьдчилан худалдагчид төлбөрийг 100% төлсөн байна.
  - 2.3 Худалдагч нь худалдан авагчийн бараа бүтээгдэхүүнийг 100% нийлүүлж нийт төлбер орсон үед нийт үнийн дүнд НӨАТ бичиж өгөх үүрэгтэй бөгөөд урьдчилгаанд НӨАТ-ын баримт бичиж өгөхгүй болно.

### ГУРАВ. БАРААГ ХҮЛЭЭН АВАХ, ЭРСДЭЛ ХУВААРИЛАХ

- 3.1 Барааг нийлүүлэх хугацаа нь худалдан авагч барааны техникийн үзүүлэлтүүд болон хүчин чадлыг баталгаажуулж урьдчилгаа төлбөр төлснөөс хойш талууд хугацааг тохиролцон барааг нийлүүлнэ.

Худалдагч тал

Худалдан авагч тал

- 3.2 Худалдан авагчид барааг шилжүүлэхдээс барааг ашиглах боломжтой эсэх, эрхийн болоод биет байдлын доголдолгүй эсэхийг худалдагч шалгаж хүлээлгэн өгөх, худалдан авагч шалгаж хүлээн авч акт үйлдэн хүлээн авна
- 3.3 Худалдагч нь барааг хүлээлгэн өгөхдөө барааны нэр төрөл, тоо ширхэг, хэмжээ гэх мэтийг дэлгэрэнгүй дурьдсан сав баглаа боодлын бичиг (packing list)-ийг урьдчилан бэлдсэн байна.

#### ДӨРӨВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

**Энэхүү гэрээний дагуу Худалдагч нь дараах эрх, үүргийг хүлээнэ. Үүнд:**

- 4.1 Бараа бүтээгдэхүүнээ тохиролцсон хугацаанд тоо, чанар, иж бүрдлийг нь шалган хүлээн авахыг худалдан авагчаас шаардах эрхтэй.
- 4.2 Барааны төлбөрийг тохиролцсон хугацаанд төлж барагдуулахыг шаардах эрхтэй;
- 4.3 Худалдагч тал бараа бүтээгдэхүүнийг хүлээн авах этгээд нь худалдан авагч талын эрх бүхий хүн гэдгийг нотолсон бичиг баримтыг авах эрхтэй.
- 4.4 Худалдан авагчид захиалсан барааг холбогдох бичиг баримт, ашиглалтын зааврын хамт тохиролцсон хугацаанд хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 4.5 Барааны хэрэглээний шинж чанар, хадгалалт, ашиглалтын горимын талаарх холбогдох гарын авлага, лавлах мэдээлэл (SDS), шинжилгээний (COA) болон гарал үүслийн гэрчилгээ (COO)-ний хамт худалдан авагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 4.6 Баталгаат хугацаанд худалдсан бараа бүтээгдэхүүнийг үнэ төлбөргүйгээр засах, солих үйлчилгээг үзүүлэх үүрэгтэй.
- 4.7 Худалдагч нь Хог хаягдлын тухай хуулийн 40.5 дугаар заалтын дагуу аюултай химиин бодис, бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав, баглаа боодлоос үүсэх хаягдлыг эргүүлэн цуглуулах үүрэгтэй.

**Энэхүү гэрээний дагуу Худалдан авагч нь дараах эрх, үүргийг хүлээнэ. Үүнд:**

- 4.8 Худалдагчаас стандартын шаардлага хангасан, баталгаатай бараа худалдахыг шаардах эрхтэй. Бараанд илэрсэн доголдлыг худалдагчид мэдэгдэж, уг доголдлыг арилгуулах, доголдолгүй ижил төрлийн бараагаар сольж өгөхийг шаардах эрхтэй.
- 4.9 Баталгаат хугацаанд худалдсан бараа бүтээгдэхүүнийг үнэ төлбөргүйгээр засах, солих үйлчилгээ үзүүлэхийг шаардах эрхтэй.
- 4.10 Худалдагчаас энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.
- 4.11 Худалдан авагч Худалдагч талд худалдан авах шаардлагатай барааны жагсаалтыг тогтмол илгээж байх үүрэгтэй.
- 4.12 Худалдан авагч тал нь химиин бодис ашиглах зөвшөөрлийн бичгийн хуулбар хувийг худалдагчид өгөх үүрэгтэй.
- 4.13 Худалдагч тал нь тухайн бараа бүтээгдэхүүнийг хүлээн авах эрх бүхий хүний талаарх мэдээллийг худалдагч талд урьдчилан өгөх үүрэгтэй.
- 4.14 Худалдан авагч нь худалдагчийн хүлээлгэн өгсөн барааг хадгалалт ашиглалтын горимын дагуу хадгалах, ашиглах үүрэгтэй.
- 4.15 Худалдагчаас барааг тоо, чанар, иж бүрдлийг нь шалгаж хүлээн авах үүрэгтэй.
- 4.16 Барааны төлбөрийг тохиролцсон хугацаанд тогтоосон журмаар төлж барагдуулах үүрэгтэй.

#### ТАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 5.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх үүрэгтэй бөгөөд гэрээний үүргээ зэрчсөнөөс нөгөө талдаа хохирол учруулсан тохиолдолд хохирлыг гэм буруутай тал нь хариуцан арилгана.
- 5.2 Хадгалалтын горим алдагдсанаас болж барааны чанарын доголдол үүсэх хариуцлагыг худалдан авагч тал хариуцана.
- 5.3 Худалдан авагч нь тохиролцсон төлбөрийг тогтоосон хугацааны дотор хийж гүйцэтгээгүй бол гүйцэтгээгүй үүргийн үнийн дунгийн 0.3 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хугацаа хэтрүүлсэн хоног тутамд худалдагчид төлнө.

Худалдагч тал

Худалдан авагч тал

- 5.4 Худалдагч нь барааг тохиролцсон хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үргийн үнийн дүнгийн 0,3 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг хугацаа хэтрүүлсэн хоног тутамд худалдан авагчид төлнө.

### **ЗУРГАА. ГЭНЭТИЙН БОЛОН ДАВАГДАШГҮЙ ХҮЧНИЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ БОЛОН МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

- 6.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал үүссэн тохиолдолд Худалдагч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар худалдан авагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Уг нөхцөл байдлаас болоод нийлүүлэлт гэрээнд заасан хугацаанаас хоцорсон тохиолдолд гэрээг гүйцэтгэх хугацааг сунгана.
- 6.2 Талууд гэрээний үүргийн биелэлтэй холбогdon гарч болох маргааныг зөвшилцөл болон хэлэлцээрээр шийдвэрлэхийг хичээнэ. Хэлэлцээрийн замаар асуудлыг шийдэж чадахгүй тохиолдолд шүүхэд хандаж Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлэнэ.

### **ДОЛОО. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ, ГЭРЭЭГ ЦУЦЛАХ**

- 7.1 Энэхүү гэрээ нь 1.5-д заасан хугацаанд үйлчлэх бөгөөд бараа бүтээгдэхүүн худалдах, худалдан авалт тухай бүрт заалтууд мөрдөгднө.
- 7.2 Гэрээ талууд сунгахаас татгалзсан тохиолдлоос бусад тохиолдолд гэрээг үргэлжилж байгаад тооцно.

### **НАЙМ. ГЭРЭЭНИЙ НУУЦЛАЛ**

- 8.1 Талууд харилцан хүлээн авсан мэдээлэл, баримт бичгийн нууцлалыг энэ гэрээ дуусгавар болсноос хойш нэг (1) жилийн туршид чанд нууцалж хадгална.
- 8.2 Талуудын хооронд шилжүүлэн өгсөн нууцын чанартай мэдээлэл, баримт бичигтэй Худалдагч, Худалдан авагчийн энэхүү гэрээний дагуу хийж байгаа ажил, үйлчилгээтэй шууд холбоо бүхий хүмүүс танилцана.
- 8.3 Талууд гэрээ байгуулсантай холбогdon шууд болон шууд бусаар мэдсэн, олж авсан, талуудтай холбоотой бизнесийн нууцад хамаарах аливаа мэдээ, мэдээлэл, баримт (үүнд: бүх төрлийн гэрээ, хэлцэл, бараа материалын үнийн санал гэх мэт)-ыг нөгөө талын зөвшөөрөлгүйгээр өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд эсвэл гэрээний нөгөө талын эсрэг ашиглахгүй, аливаа гуравдагч этгээдэд амаар буюу бичгээр задруулахгүй, дамжуулахгүй байх үүргийг хүлээнэ.

### **ЕС. МЭДЭГДЭЛ**

- 9.1 Энэхүү гэрээний дагуу нэг талаас нөгөө талд хүргүүлэх аливаа мэдэгдэл, албан бичиг, бусад баримт бичгийг бичгээр үйлдэх бөгөөд биечлэн, факсаар, эсхүл Талуудын эрх бүхий этгээдүүд зөвшөөрсөн бусад хэрэгслээр, доорх хаягаар хүргүүлнэ. Үүнд:

Худалдагч талын хаяг: Улаанбаатар хот, БЗД, 25-р хороо Олзой гудамж, #22  
Утас: 88008923, Факс: 70153199

Худалдан авагчийн хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 27-р хороо, 21-р хороолол, "Түмэн Шувуут" ХК-ийн байр  
Утас: 99010558, Факс: 70005225

### **АРАВ. БУСАД ЗҮЙЛ**

- 10.1. Хүчин төгөлдөр болох. Энэхүү Гэрээнд Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.
- 10.2. Нэмэлт, өөрчлөлт. Энэхүү Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж. Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болсонд тооцно.
- 10.3. Гэрээний нэгдмэл байдал. Энэхүү Гэрээ нь Талуудын хооронд амаар болон бичгээр үйлдэгдсэн бүхий л урьдчилсан тохиролцоо, мэдэгдэл, баталгаа болон хэлэлцээрийг

Худалдагч тал

Худалдан авагч тал


орлох бөгөөд Гэрээ нь бүхэлдээ Гэрээнд заасан харилцааг зохицуулсан үндсэн баримт бичиг байх болно.

- 10.4. Tусгаар байдал. Энэхүү Гэрээний аливаа заалт хууль бус буюу хүчин төгөлдөр бусад тооцогдсон нь Талуудын хооронд тохирсон Гэрээний бусад нөхцлийн хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй бөгөөд тэдгээр нь хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.
- 10.5. Гэрээний хувь. Энэхүү Гэрээг турван /2/ эх хувь үйлдэх бөгөөд Талууд гарын үсэг зурж, нөгөө талдаа харилцан хүргүүлснээр баталгаажуулсанд тооцогдоно.

#### ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:


Худалдагч талыг төлөөлж:

Борлуулалтын албаны дарга Н.Туул

/  /

Утас: 88073199

Менежер О.Халиунаа

/  /

Утас: 80225588


Худалдан авагч талыг төлөөлж:

Борлуулалтын албаны дарга Б.Мөнгентуяа

/  /

Утас: 88006761

Чанарын менежер Ш.Алтантуяа

/  /

Утас: 99010558

Худалдагч тал

Худалдан авагч тал

2020 оны 6 сарын 8 өдрийн  
тоот гэрээний хавсралт-1

1. Барааны тодорхойлолт

№	Барааны нэр, загвар	Барааны тодорхойлолт	Зарцуулалт	
			Сард	Жилд
Тэжээлт орчин				
1	Plate Count Agar (PCA)		75-80гр	900-1000гр
2	Endo Agar		40-50гр	450-500гр
3	Pseudomonas Isolation Agar Base		75-80гр	900-1000гр
4	Peptone Water		90-100гр	1100-1300гр
5	Xylose Lysine Deoxycholate agar (XLD)		45-50гр	550-650гр
6	Sabouraud Dextrose Agar		35-45гр	400-500гр
7	Egg yolk Emulsion		30-40гр	350-450гр
8	Baird Parker Agar Base		40-50гр	450-550гр
9	Salmonella-Shigella (SS) Agar		60-70гр	750-850гр
10	Glycerol		30-40гр	400-500гр
11	Columbia Blood Agar Base		-	10-20гр
12	Brilliant Green Agar		-	15-25гр
13	Bacillus Cereus Agar Base		-	15-25гр
14	Listeria Selective Agar Base		-	15-25гр
15	Tryptone Soya Broth		-	5-10гр
16	Tryptone Water		-	3-5гр
17	Lauryl Sulphate Broth		-	5-10гр
18	Simmons Citrate Agar		-	5-10гр
19	Triple Sugar Iron (TSI) Agar		-	10-20гр
Урвалж				
20	Sodium Dihydrogen Phosphate	Натриин гидрофосфат $\text{NaH}_2\text{PO}_4 \cdot 2\text{H}_2\text{O}$	40-50гр	500-600гр
21	Sodium Thiosulfate	Натриийн тиосульфат $\text{Na}_2\text{S}_2\text{O}_3 \cdot 5\text{H}_2\text{O}$	-	5-10гр
22	Sodium Phosphate Dibasic Dodecahydrate	Натриийн гидрофосфат $\text{Na}_2\text{HPO}_4 \cdot 12\text{H}_2\text{O}$	-	5-10гр
23	Potassium Tellurite 1%	Калийн теллурит 1% $\text{K}_2\text{TeO}_3$	-	3-5мл
24	Kovac's Indole Reagent	Ковачийн Индол урвалж	-	2-5мл
25	Methyl red	Метилийн улаан	-	2-5мл
26	Methyl blue	Метилийн хех	-	2-5мл
27	Crystal Violet	Кристалл виолет	-	2-5мл
28	Solution Lugoli	Люголийн усмал	-	2-5мл
29	Fuchsin	Фуксин	-	2-5мл
30	Buffer Solution pH 4.01	Буфер усмал pH 4.01	-	2-5мл
31	Buffer Solution pH 7.00	Буфер усмал pH 7.00	-	2-5мл
Фиксаналь				
32	Trilon B, 0.1N	Трилон Б, 0.1N	-	15ш
33	Sodium Hydroxide, 0.1N	Натрийн шүлт ( $\text{NaOH}$ ), 0.1N	-	10ш
34	Potassium Hydroxide, 0.1N	Калийн шүлт ( $\text{KOH}$ ), 0.1N	-	5ш
35	Hydrogen Chloride, 0.1N	Давсны хүчил ( $\text{HCl}$ ), 0.1N	-	40ш
Хүчил				
36	Boric Acid, $\text{H}_3\text{BO}_3$	Борын хүчил, $\text{H}_3\text{BO}_3$	-	1кг
37	Hydrogen Chloride, HCl	Давсны хүчил, HCl	-	12л
38	Sulfuric Acid, $\text{H}_2\text{SO}_4$	Хүхрийн хүчил, $\text{H}_2\text{SO}_4$	-	15л
39	Nitric Acid, $\text{HNO}_3$	Азотын хүчил, $\text{HNO}_3$	-	1л
Шүлт (талстаар)				
40	Potassium Hydroxide, KOH	Калийн шүлт, KOH	-	1кг
41	Sodium Hydroxide, NaOH	Натрийн шүлт, NaOH	-	15кг
Давс				
42	Potassium Chloride, KCl	Калийн хлорид, KCl	-	0.5кг
43	Potassium Chromate, $\text{K}_2\text{Cr}_2\text{O}_4$	Калийн бихромат, $\text{K}_2\text{Cr}_2\text{O}_4$	-	0.5кг

Худалдач тал

Худалдан авагч тал

44	Potassium dihydrogen phosphate, $\text{KH}_2\text{PO}_4$	Фосфор хүчлийн кали, $\text{KH}_2\text{PO}_4$	-	0.5кг
45	Ammonium molybdate tetrahydrate, $(\text{NH}_4)_6\text{Mo}_7\text{O}_{24} \cdot 4\text{H}_2\text{O}$	Аммониум молебдин, $(\text{NH}_4)_6\text{Mo}_7\text{O}_{24} \cdot 4\text{H}_2\text{O}$	-	0.5кг
46	Ammonium metavanadate, $\text{NH}_4\text{VO}_3$	Аммониум метаванадат, $\text{NH}_4\text{VO}_3$	-	0.5кг
47	Sodium Chloride, $\text{NaCl}$	Натрийн хлорид, $\text{NaCl}$	-	1кг
48	Silica gel	Силикагель	-	1.5кг
49	Magnesium Sulfate, $\text{MgSO}_4$	Магни сульфат, $\text{MgSO}_4$	-	0.5кг
50	Ammonium Hydroxide, $\text{NH}_4\text{OH}$	Аммиак, $(\text{NH}_4\text{OH}) 25\%$	-	0.5кг
51	Ammonium chloride, $\text{NH}_4\text{Cl}$	Аммоны хлорид, $\text{NH}_4\text{Cl}$	-	0.5кг
52	Copper (II) sulfate, $\text{CuSO}_4$	Зэсийн сульфат, $\text{CuSO}_4$	-	0.5кг
53	Potassium sulfate $\text{K}_2\text{SO}_4$	Калийн сульфат, $\text{K}_2\text{SO}_4$	-	0.5кг
<b>Органик бодис</b>				
54	Sodium Citrate, Dihydrate, $\text{C}_6\text{H}_5\text{Na}_3\text{O}_7 \cdot 2\text{H}_2\text{O}$	Лимон хүчлийн натри, $\text{C}_6\text{H}_5\text{Na}_3\text{O}_7 \cdot 2\text{H}_2\text{O}$	-	1.0кг
55	Acetone, $\text{CH}_3\text{COCH}_3$	Ацетон, $\text{CH}_3\text{COCH}_3$	-	2.0кг
56	Hexane, $\text{CH}_3(\text{CH}_2)_4\text{CH}_3$	Гексан, $\text{CH}_3(\text{CH}_2)_4\text{CH}_3$	-	15л
57	Үүргийн катализатор	Protein Promoter	-	1000ш
58	Phenol, $\text{C}_6\text{H}_5\text{OH}$	Спирт, $\text{C}_6\text{H}_5\text{OH}$	-	5.0л
59	Acetic Acid, $\text{CH}_3\text{COOH}$	Цууны хүчил, $\text{CH}_3\text{COOH}$	-	0.5л
60	Activated Carbon	Идэвхижүүлсэн нүүрс	-	0.5кг
61	Starch, $\text{C}_6\text{H}_{10}\text{O}_5$	Цардуул, $\text{C}_6\text{H}_{10}\text{O}_5$	-	0.5кг
62	Ether	Эфир	-	0.5л
63	Ethylene diamine anhydrous, $\text{C}_2\text{H}_8\text{N}_2$	Этилен диамин, $\text{C}_2\text{H}_8\text{N}_2$	-	0.5л
64	Triethanolamine, $\text{N}(\text{CH}_2\text{CH}_2\text{OH})_3$	Триэтаноламин, $\text{N}(\text{CH}_2\text{CH}_2\text{OH})_3$	-	0.5л
<b>Индикатор бодис</b>				
65	Methylthymol Blue	Метилтимол хөх	-	25гр
66	Eriochrome Black T	Эрихром хар	-	25гр
67	Phenolphthalein, $\text{C}_{20}\text{H}_{14}\text{O}_4$	Фенолфталейн, $\text{C}_{20}\text{H}_{14}\text{O}_4$	-	25гр
68	Murexide, $\text{C}_9\text{H}_8\text{N}_6\text{O}_6$	Мурексид, $\text{C}_9\text{H}_8\text{N}_6\text{O}_6$	-	25гр
69	Methyl Red, $\text{C}_{15}\text{H}_{15}\text{N}_3\text{O}_2$	Метил улаан, $\text{C}_{15}\text{H}_{15}\text{N}_3\text{O}_2$	-	25гр
70	Methyl Blue, $\text{C}_{16}\text{H}_{18}\text{ClN}_3\text{S} \cdot 3\text{H}_2\text{O}$	Метилен хөх, $\text{C}_{16}\text{H}_{18}\text{ClN}_3\text{S} \cdot 3\text{H}_2\text{O}$	-	25гр
71	Malachit green, $\text{C}_{23}\text{H}_{25}\text{ClN}_2$	Малахит ногоон, $\text{C}_{23}\text{H}_{25}\text{ClN}_2$	-	25гр
72	Calconcarboxylic acid, $\text{C}_{21}\text{H}_{14}\text{N}_2\text{O}_7\text{S}$	Калконкарбоксилийн хүчил, $\text{C}_{21}\text{H}_{14}\text{N}_2\text{O}_7\text{S}$	-	25гр

Худалдагч талийг төлөөлж:  
Менежер: О.Халиунаа

Халиунаа

Худалдан авагчийг төлөөлж:  
Чанарын менежер: Ш.Алтантуяа

Ш.Алтантуяа

Худалдагч тал

Худалдан авагч тал

БАТЛАВ: ШИНЭ УЯНГА ХХК-НЫ  
ЗАХИРАЛ  
Д.ЭНХТҮҮВШИН

БАТЛАВ: "ТҮМЭН ШУВУУТ" ХК-НЫ  
ЗАХИРАЛ  
Ж.БОЛД

**МИДЛИНГ (БАЯЖУУЛСАН НҮҮРС-MNS 6457:200014) ХУДАЛДАХ,  
ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ**

2022 оны 09 дугаар  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

№

Энэхүү мидлинг (баяжуулсан нүүрс-MNS 6457:200014) худалдах, худалдан авах гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г Монгол Улсын Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйлүүдийг үндэслэн, нэг талаас “Шинэ Уянга” ХХК /РД:5565057/-ийг төлөөлөн Захирал ажилтай Дашдандог овогтой Энхтүүвшин (цаашид Худалдагч гэх) нөгөө талаас “Түмэн Шувуут” ХК /РД: 2844753/-ийг төлөөлөн ХБАЭА ажилтай Цагаанчулуун овогтой Нямдорж (цаашид Худалдан авагч гэх) дараах зүйлсийг харилцан тохиролцож байгуулав.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Энэхүү гэрээгээр Худалдагч нь гэрээнд заасан шаардлага хангасан мидлинг (баяжуулсан нүүрс) (цаашид “Бараа бүтээгдэхүүн” гэх)-ийг чанар, стандартын дагуу нийлүүлэх, Худалдан авагч тал нь мидлингийг худалдан авахтай холбоотой талуудын эрх үүрэг, хариуцлагыг тодорхойл@ox мөн харилцааг зохицуулахад гэрээний зорилго оршино.
- 1.2. Худалдагч нь Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62-р тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн “Нам даалтын өхөн зууханд түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” А/1377 тоот захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Уур үйлдвэрлэгчдийн технологийн зуухуудад сайжруулсан түлш хэрэглэх бодит судалгааг МБМҮйлдвэрлэгчдийн холбоо, ШУТИС-ийн эрдэмтэн багш нар хийсний үр дүнгээр хийн зууханд мидлинг (баяжуулсан нүүрс-MNS 6457:200014) (5000 ккал дээш) хэрэглүүлэхийг үүрэг болгосны дагуу худалдан авагч талд дээрх шаардлага хангасан ..... (.....) тонн мидлинг (баяжуулсан нүүрс) нийлүүлнэ.

**Хоёр. Гэрээний хугацаа**

- 2.1 Энэхүү гэрээ нь талууд гэрээнд гарын үсэг зурж, тамга тэмдэгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 2.2 Гэрээний хугацаа нь гэрээ хүчин төгөлдөр болж баталгаажсанаас хойш 1 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

2.3 Талууд харилцан тохиролцож гэрээний хугацааг сунгах буюу гэрээнд нэмэлт өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулах бөгөөд гарын үсэг зурж, тамга дарснаар энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

### **Гурав. Гэрээний үнэ, төлбөр тооцоо**

- 3.1 Худалдагч нь худалдан авагчийн өгсөн захиалгын дагуу мидлинг (баяжуулсан нүүрс) нийлүүлэх бөгөөд 1 тн-ын үнэ 165000 ( иэг зуун жаран таван мянган ) төгрөг байна. Энэхүү үнийн дунд /НОАТ орсон болно/.
- 3.2 Мидлинг худалдан авах захиалга өгөхдөө тоо хэмжээг худалдан авагч тал тодорхой зааж өгөх ба нэг удаагийн тээврийн ачааны доод хэмжээ 40 тонн байна.
- 3.3 Худалдан авагч нь мидлинг нүүрс хүлээн авсан өдрөөс хойш 3 хоногийн дотор хүлээн авсан тоо хэмжээгээр худалдагч талд бараа бүтээгдэхүүний үнийг “Шинэ Уянга” ХХК-ний “Хас” банкны 5000 48 69 07, “Хаан” банкны 51 23 088 538 тоот дансанд шилжүүлж төлне.

### **Дөрөв. Худалдан авагч талын эрх, үүрэг**

- 4.1 Худалдан авагч тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Худалдагчаас шаардах эрхтэй.
- 4.2 Худалдан авагч тал нь захиалга өгсөнөөс хойш гэрээнд заасан хугацаанд мидлингээ талбай дээр буулгахыг худалдагч талаас шаардах эрхтэй.
- 4.3 Мидлингийн чанар стандарт тоо хэмжээнд хяналт тавьж шаардлагад нийцсэн эсэхийг шалгах эрхтэй.
- 4.4 Худалдан авагч тал бүтээгдэхүүн хүлээн авах хугацаагаа графикаар худалдагч талд гаргаж өгөх үүрэгтэй .
- 4.5 Худалдан авагч нь барааг хүлээн авч, буулгах талбайг бэлэн байлгах, ачааг саадгүй буулгах нөхцлөөр хангах үүрэгтэй.
- 4.6 Барааг түргэн, шуурхай хүлээн авч, тээврийн машиныг чөлөөлөх үүрэгтэй.
- 4.7 Гэрээгээр тохиролцсон төлбөрийг хугацаандаа бүрэн төлж барагдуулах үүрэгтэй.
- 4.8 Мидлингийг талбайд буулгах үед барааны чанарт шалгалт хийж пүүний баримтаар хүлээн авах үүрэгтэй.
- 4.9 Худалдан авагч бараа бүтээгдэхүүнийг хүлээн авсныг гэрчлэх тодорхой үйлдэл хийсэн эсвэл пүүний баримтыгавсанаар түүнийг хүлээн авсанд тооцино.
- 4.10 Худалдан авагч тал мидлингийн захиалгыг 7-10 хоногийн өмнө худалдагч талд мэдэгдэх үүрэгтэй.

### **Тав. Худалдагчийн эрх, үүрэг**

- 5.1 Худалдан авагч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.
- 5.2 Мидлингийг тээврийн хэрэгслийн өөрийн батлагдсан даацад үндэслэн ачих эрхтэй.
- 5.3 Гэрээний төлбөрийг хугацаандаа бүрэн төлөхийг шаардах эрхтэй.
- 5.4 Худалдагч тал нь гэрээнд заасан мидлинг нийлүүлж, худалдан авагч талд бараа материалын зарлагын баримт эсвэл пүүний баримтаар хүлээлгэн өгөх үүрэгтэй.

- 5.5 Худалдагч тал нь Худалдан авагч талын захиалсан бараа бүтээгдэхүүний тээврлэлтийг бүрэн хариуцаж худалдан авагч талын талбай дээр буулгах үүрэгтэй.
- 5.6 Худалдагч нь Худалдан авагч талын бараа бүтээгдэхүүнийг захиалгын дагуу тогтоосон хугацаанд түргэн шуурхай тасралтгүй нийлүүлэх үүрэгтэй.
- 5.7 Худалдагч нь бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх хуваарь өгснөөс хойш календарын 5-7 хоногийн дотор нийлүүлнэ.

#### **Зургаа. Талуудын хариуцлага**

- 6.1 Гэрээний талууд гэрээний үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйн улмаас нөгөө талд учирсан шууд болон шууд бус хохирол, гомдлыг барагдуулна.
- 6.2 Худалдан авагч нь төлбөрийг гэрээгээр тохиролцсон хугацаанд төлөөгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3%-иар тооцож хоног тутамд алданги төлнө.
- 6.3 Худалдагч тал нь бараа бүтээгдэхүүний захиалгыг тогтоосон хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үнийн дүнгийн 0.3%-иар тооцож хоног тутамд алданги төлнө.
- 6.4 Гэрээний талууд хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөний улмаас аль нэг талд хохирол учирсан тохиолдолд уг хохирлыг гэм буруутай тал нь хохирлыг бүрэн хариуцаж, арилгах үүрэгтэй.

#### **Долоо. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл**

- 7.1 Гэнэтийн, давагдашгүй хүчин зүйлийн улмаас худалдан авагч тал болон худалдагч нь гэрээгээр хүлээсэн үүргээ зохих хугацаанд хийж гүйцэтгээгүй бол шаардлагатай хугацаагаар түүнийг гүйцэтгэх хугацааг сунгаж болно.
- 7.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлд гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер г.м байгалийн гамшиг, хорио цээр гэх мэт талуудын хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлыг ойлгоно.
- 7.3 Мидлинг бууснаас хойш давагдашгүй хүчин(хөл хорио тогтоох, онц байдал зарлах, байгалийн гамшиг .... гэх мэт) зүйл тохиолдвол үүнийг төлбөр төлөхгүй байх нөхцөл гэж үзэхгүй.

#### **Найм. Нууц хадгалах ба баталгаа**

- 8.1 Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж мэдсэн байгууллага, хувь хүний нууцад хамаарах аливаа мэдээ мэдээллийг бусдад бичгэн буюу аман хэлбэрээр задруулах, гэрээнд зааснаас өөр зорилгоор ашиглах эрхгүй.
- 8.2 Нууц хадгалахтай холбоотой үүргээ зөрчсөн тал нөгөө талдаа учруулсан хохирлыг бүрэн хариуцина.
- 8.3 Энэ заалт нь бараа нийлүүлэлтийн бүх ажилтан, төлөөлөгчид болон туслан гүйцэтгэгч /хэрэв байгаа бол/ нарт нэгэн адил хамаарна.

#### **Ес. Гэрээг цуцлах, дуусгавар болгох**

- 9.1 Талууд харилцан тохиролцож гэрээг цуцалж болно.
- 9.2 Аль нэг тал гэрээг дангаар цуцлах хүсэлт гаргах эрхтэй бөгөөд энэ хүсэлтээ 14-өөс доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэх бөгөөд албан бичигт гэрээг цуцлах шалтгаан, нөхцлийг дэлгэрэнгүй тусгасан байна.
- 9.3 Гэрээний нөхцлүүд бүрэн биелэгдсэнээр гэрээний хугацаа дууч 2 тал гэрээг сунгаагүй тохиололд гэрээг дуусгавар болсонд тооцно.

#### **Арав. Маргаан шийдвэрлэх**

- 10.1 Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал, зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх аргаар шийдвэрлэнэ.
- 10.2 Маргаан болон зөрөлдөөнийг зөвшилцөх аргаар шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### **Арван нэг. Бусад зүйл**

- 11.1 Гэрээ нь талуудын бүрэн эрхт төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж, гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэнээр дуусгавар болно.
- 11.2 Энэхүү гэрээ талуудын эрх ашиг, сонирхлын төлөө байгуулагдсан бөгөөд талуудын хувьд зайлшгүй дагаж мөрдөх баримт бичиг мөн.
- 11.3 Гэрээний аль нэг талын хүсэлтээр гэрээний нөхцөл нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага гарвал талууд харилцан тохиролцож, зөвшилцсөний үндсэн дээр гэрээнд бичгээр нэмэлт өөрчлөлт оруулах бөгөөд энэ нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 11.4 Талуудын Үүсгэн байгуулагчид, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал, бусад өмчлөгчид өөрчлөгдсөнөөс үл хамааран гэрээ хүчин төгөлдөр байна.
- 11.5 Монгол Улсын эрх бүхий териин байгууллагаас холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулсан, нэмэлт тайлбар хийсэн, тухайн орд газраас борлуулах нүүрсний үнийг шинэчлэн тогтоосон, нүүрсний татвар хураамжийг нэмэгдүүлсэн, дотоодын зах зээл дэх шатахууны үнэ, нүүрсний үнийн хэлбэлзэл зэрэг хүчин зүйлээс хамаарч талууд тохиролцон гэрээний үнэнд өөрчлөлт оруулна.
- 11.6 Гэрээг монгол хэл дээр хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.
- 11.7 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

#### **Гэрээ байгуулсан:**



4

ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Түмэн Шувуут ХК-ны ХБАЭА  
Шүрэнжав Д. Нямдорж  
Хаяг: СХД, 27 хороо, 59 тоот  
Утас: 70005225, 98000010

БАТЛАВ: "ТҮМЭН ШУВУУТ" ХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ж.БОЛД

БАЯЖУУЛСАН НҮҮРС ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2022/10/13

Дугаар:

Улаанбаатар хот

Энэхүү баяжуулсан нүүрс худалдах, худалдан авах гэрээг (цаашид "Гэрээ" гэх) нэг талаас Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, БИЗНЕС ТАУР – 902 хаягт байрлах "ACMOS" ХХК (регистрийн дугаар: 2094592) (цаашид "Нийлүүлэгч" гэх).

Нэгөө талаас: ХУД-ийн 13 хороо туул тосгонд байрлах "Түмэн Шувуут" ХК (регистрийн дугаар: 2844753) (цаашид "Худалдан авагч", Нийлүүлэгч болон худалдан авагчийг хамтад нь "Талууд" гэх) нар дараах нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

**Нэг. Ерөнхий зүйл :**

- 1.1 Энэ гэрээг 2022 оны 10 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг дуустал хугацаанд баяжуулсан нүүрс нийлүүлэх, худалдан авах болон түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах зорилгоор байгуулав.
- 1.2 Багануур дүүрэгт байрлах өөрийн баяжуулах үйлдвэрт Багануурын уурхайн түүхий нүүрсийг 0-300 хэмжээнд шигшиж, ОХУ-ын "HTC" корпорацийн нүүрсний шаталтыг дэмжигч ТМУ бүтээгдэхүүнээр баяжуулан, 25 кг, 1 тн шуудайд ачиж нийлүүлнэ.
- 1.3 Гэрээний хугацаанд нийт 1760 тонн баяжуулсан нүүрс нийлүүлнэ.

**Хоёр: Бүтээгдэхүүний үнэ, чанар, жин**

- 2.1 Нэг тонн баяжуулсан нүүрсний үнийг бутармагийн хэмжээгээр доорх үнээр тооцно.
  - 2.1.1 0-15 мм /нуунтаг/, 15мм-30мм /бүхэл/ нүүрсний үнэ 120,000 төгрөг /нэг зуун хорин мянга/ /НӨАТ орсон/
  - 2.1.2 "Асмос" ХХК-ийн машинаар тээвэрлүүлэх бол 1 тн тутмыг 45000/дөчин тав/ мянган төгрөгөөр тооцно.
  - 2.1.3 25 кг тутмын шуудайны үнэ 800 төгрөг бөгөөд бараа хүлээн авч хэрэглэсэний дараа гэмтэлгүй бүтэн буцааж өгөх үүргийн хүлээнэ. Гэмтэлтэй шуудайны үнийг 800 /найман зуу/ төгрөгөөр тооцно.
- 2.2 Нүүрсний чанарын үзүүлэлт нь Стандартчилал Хэмжил Зүйн Үндэсний Төвийн тогтоосны дагуу MNS 6457:2022 стандарт бүхий Дулаан гаргах чадвар 3500ккл/кг, /+200/ эрчим хүчний нүүрс байна.
- 2.3 Баяжуулсан нүүрсний жинг Нийлүүлэгч талын пүүгээр тодорхойлно.
- 2.4 Пүүг зохих хуулийн дагуу 6 сар тутам баталгаажуулна.

Нийлүүлэгч тал:

Захиалагч тал:

БАТЛАВ: "ACMOS" ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХРАЛ



Б.ДЭЛГЭРМАА



### **Гурав. Нийлүүлэгчийн эрх үүрэг**

- 3.1 Нийлүүлэгч нь энэхүү гэрээний хавсралт №1- д заасан хэмжээ, чанар бүхий баяжуулсан нүүрсийг Худалдан авагчид нийлүүлнэ.
  - 3.2 Худалдан авагчийн ачсан баяжуулсан нүүрсийг жигнэж, холбогдох бичиг баримтыг хүлээлгэн өгснөөр өмчлөлийн үр шим хүртэх эрх болон эрсдэл худалдан авагчид шилжинэ.
  - 3.3 Сар бүрийн баяжуулсан нүүрсний нийлүүлэлтийн дүгнэлт үйлдэхэд үүссэн аливаа хүндрэлийг шийдвэрлэх зорилгоор худалдан авагч талаас илгээсэн багийн гишүүдийг бодит дүгнэлт гаргах орчин, нөхцөл, нэвтрэх эрхээр хангах үүрэгтэй.
  - 3.4 Хэрэглэгч нь тухайн сард авах баяжуулсан нүүрсний нийт төлбөрийн 30 хувийг урдчилан төлөх ба төлбөр хийгдээгүйн улмаас нийлүүлэгчид үүсэх хохирлыг нийлүүлэгч тал хариуцахгүй.
  - 3.5 Худалдан авагч гэрээний үүргээ биелүүлэхгүй, гэрээний зөрчлөө заасан хугацаанд арилгаагүй, арилгахаас татгалзсан тохиолдолд Нийлүүлэгч гэрээг дангаараа цуцлах эрхтэй.

Дөрөв. Худалдан авагчийн эрх үүрэг

- 4.1. Нийлүүлэгч Худалдан авагчид тохирсон чанар, стандартын баяжуулсан нүүрсийг захиалгын дагуу хугацаа алдалгүй нийлүүлэх үүрэгтэй.
  - 4.2. Баяжуулсан нүүрсний чанартай холбоотой гомдлын шаардлагыг тухайн ачилтыг хүлээн авснаас хойш 48 цагийн дотор бичгээр гаргах эрхтэй байна. /Бичгийг факс болон цахим шуудангаар явуулж болно/
  - 4.3. Худалдан авагч нь нийлүүлсэн баяжуулсан нүүрсний үнийг энхүү гэрээнд заасан төлбөрийн нөхцлөөр төлнө.
  - 4.4. Худалдан авагч нь авто машинаар худалдан авалт хийхдээ баяжуулсан нүүрсийг өөрсдийн тээврийн хэрэгслэлээр, захиалгаар “Асмос” ХХК-ийн тээврийн хэрэгслэлүүдээр татаж авна.
  - 4.5. Худалдан авагч нь автомшинаар баяжуулсан нүүрс ачиж тээвэрлэх зориулалт бүхий талбайд нэвтэрч тээвэрлэлт хийхдээ нийлүүлэгчийн үйл ажиллагааг зохицуулсан дүрэм, журам, зааварчилгаа, аюулгүй ажиллагааны дүрмийг дагаж мөрдөнө.
  - 4.6. Худалдан авагч энхүү гэрээний дагуу гэрээний хавсралт №1-д заасан хэмжээний баяжуулсан нүүрсийг худалдан авах үүрэгтэй.

### Тав. Төлбөр тооцоо

- 5.1 Баяжуулсан нүүрсний үнийг сар бүрийн захиалга өгөх бүрд 20 хувийг урьдчилан төлнө.

5.2 Баяжуулсан нүүрсний үнийн төлбөрийг нийлүүлэгчийн дараах дансанд гүйцэтгэнэ.

## Банкны нэр: ТӨРИЙН БАНК

Дансны дугаар: 100000329688

Нийлүүлэгч тал: .....

### Захиалагы тап:

H.B.G.

### **Зургаа. Талуудын хүлээх хариуцлага**

- 6.1 Баяжуулсан нүүрсний төлбөрийг энэхүү гэрээний 5.2 дахь заалтын дагуу төлөөгүй нөхцөлд Нийлүүлэгч нь нийлүүлэлтийг зогсоон.
- 6.2 6.1 заалтаас шалтгаалан үүссэн хохирлыг нийлүүлэгч тал хариуцахгүй.
- 6.3 Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах саналтай бол саналыг ажлын гурав хоногийн дотор нөгөө талд бичгээр мэдэгдэнэ.
- 6.4 Нийлүүлэгч нь энэхүү гэрээний 6.3 дахь заалтын дагуу өөрсдийн саналыг худалдан авагчид мэдэгдснээс хойш ажлын гурав хоног дотор худалдана авагчаас ямар нэгэн санал мэдэгдэл ирүүлээгүй болон уг саналд худалдан авагчтай тохиролцоонд хүрээгүй бол нийлүүлэлтийг зогсоох эрхтэй.
- 6.5 Талууд гэрээний үүргээ зөрчсөнөөс нөгөө талд учирсан шууд болон шууд бус хохирлыг гэрээ зөрчсөн гэм буруутай тал хариуцан арилгана.

### **Долоо: Давагдашгүй хүчин зүйл**

- 7.1 Байгалийн гамшиг /аянга, түймэр, усны үер, газар хөдлөлт, хүчтэй салхи, дайн байлдаан, ажил хаялт/ зэрэг давтагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалан учирсан хохирлыг талууд хариуцахгүй.

### **Найм. Бусад зүйл**

- 8.1 Энэхүү гэрээгээр зохицуулагдаж буй аливаа нөхцөлд өөрчлөлт орох тохиолдолд талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт хийх ба уг нэмэлт өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.
- 8.2 Гэрээнд талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох гэрээ цуцлагдсан, гэрээний хугацаа дууссанаар эсхүл гэрээний эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлснээр дуусгавар болно.
- 8.3 Энэхүү гэрээнээс үүссэн болон холбогдон гарсан түүнчлэн уг тэрээг зөрчих, дуусгавар болгох, хүчингүй болгохтой холбоотой бүх маргааныг хуульд заасны дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**

#### **Нийлүүлэгчийг төлөөлж:**

“Асмос” ХХК-ний менежер  
..... Б.Цэдэн  
Борлуулалтын менежер  
..... Ц.Гантулга./  
Ерөнхий нягтлан бодогч  
.....  
Цахим хаяг: [tseden@mail.ru](mailto:tseden@mail.ru)  
Утас: 88101900,86406699,85406699

#### **Нийлүүлэгчийг төлөөлж:**

“Түмэн Шувуут” ХК-ний ХБАЭА  
..... Ц.Нямдорж  
Ерөнхий нягтлан бодогч  
..... М.Должинсүрэн/  
Гэрээ хариуцсан менежер  
..... Д.Болортuya/  
Цахим хаяг:  
[bolortuya.d@tumenshuvuut.mn](mailto:bolortuya.d@tumenshuvuut.mn)  
Утас: 80617781, 88000373, 88094356

Нийлүүлэгч тал:

Захиалагч тал:



*А.Б.*

- 3.2 Захиалагч нь ажлын явц, чанарт хяналт тавьж, зааварчилгаа өгнө.
- 3.3 Гүйцэтгэгч байгууллага ажлын захиалгыг тухайн хугацаанд ирж гүйцэтгээгүй тохиолдолд өөр байгууллагаар гүйцэтгүүлэх.
- 3.4 Гэрээнд заасан төлбөрийг хугацаанд нь бүрэн төлнө.

#### **Дөрөв. Гүйцэтгэгч байгууллагын эрх үүрэг**

- 4.1 Гүйцэтгэгч байгууллага нь захиалагч байгууллагын өгсөн яаралтай дуудлагын дагуу цаг алдалгүй очиж, зааварчилгааны дагуу ажлыг гүйцэтгэнэ.
- 4.2 Ажлыг өндөр хүчин чадалтай, зориулалтын тоног төхөөрөмжтэй, багтаамж ихтэй стандарт авто машинуудаар тээвэрлэх бөгөөд олон жилийн туршлагатай мэргэшсэн жолооч нараар гүйцэтгэнэ.
- 4.2 Гэрээт ажлыг гүйцэтгэх явцад гүйцэтгэгчийн буруугаас илэрсэн хохирлыг өөрийн зардлаар бүрэн хариуцна.
- 4.3 Түлш, шатахууны үнэ зах зээлийн ханшаар өөрчлөгдсөн тохиолдолд бохир ус тээвэрлэх ажлын хөлсийг шинээр тохиролцон тогтооно.
- 4.4 Захиалагч байгууллагаас гүйцэтгэсэн ажлын хөлс төлөхийг шаардах эрхтэй.

#### **Тав. Талуудын хүлээх хариуцлага**

- 5.1 Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс негөө талд учирсан хохирлыг бүрэн хариуцаж , арилгах үүрэгтэй .

#### **Зургаа. Бусад зүйлс**

- 6.1 Талууд гэрээний хугацаанд харилцан ашигтай , найрсаг байдлаар хамтран ажиллах бөгөөд аливаа маргааныг зөвшилцлийн замаар харилцан буулт хийх аргаар шийдвэрлэх бөгөөд шийдвэрлэсэн асуудлын талаар протокол хөтөлнө.
- 6.2 Талууд аливаа маргаантай асуудлаар зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд хуулийн дагуу харьяалагдах шүүхээр шийдвэрлүүлнэ.

**Долоо. Гэрээний хүчинтэй байх болон үйлчлэх хугацаа**

- 7.1 Энэхүү гэрээг 2 тал харилцан тохиролцож гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс хүчинтэй.
- 7.2 Гэрээний хүчинтэй хугацаа нь гэрээ байгуулсан өдрөөс хойш 1 жил байна.

**Гэрээ байгуулсан:**

Гүйцэтгэгч:  
“Галтай Чойндон” ХХК  
Ерөнхий захирал И.Бүннтогтох  
/...Бүннтогтох  
ГАЛТАЙ ЧОЙНДОН ХХК  
ЧААНБААТАР ХОТ  
Утас: 88116498

Захиалагч:  
“Түмэн шувуут” ХК  
ЧИСЭН БОРГИЙН ДАРГЫН Ч.Дамжуул  
А.Номиджийн Доржсүрэн  
ТҮМЭН ШУВУУТ  
УДААНЫ САЛАГ  
Утас: 88004745

Дуудлагын утас: **96005498**